



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/74

Пионер толгой

"Бид Хонгорын залуус-2023" Залуучуудын
нэгдсэн чуулганд оролцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ний 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Залуучуудын манлайлал, багаар ажиллах ур чадварыг хөгжүүлэх, аймгийн залуучуудын асуудал эрхэлсэн төрийн болон төрийн бус байгууллагуудын алсын хараа, бодлогын уялдааг сайжруулах, тэдний эрх ашигт эерэгээр нөлөөлөх зорилгоор зохион байгуулж буй "Бид Хонгорын залуус-2023" Залуучуудын нэгдсэн чуулганд сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Гантулга)-аар ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй төлөөллийг оролцуулсугай.

2.Тус чуулганд оролцох залуучуудын (Гурванбулаг-Баянхонгор-Эрдэнэцогт-Өвгөнжаргалант) оролцооны зардалд сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 500,000 (Таван зуун мянга) төгрөг гарган олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Гантулга), нягтлан бодогч (Б.Дэлгэрдалай) нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ГАНТУЛГА